

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ 2024 ОНЫ ТАЙЛАН

2025 оны 02 дугаар сарын 19

Улаанбаатар хот

НЭГ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ЗОРИЛГО

Хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго нь Хот байгуулалт, хотын стандартын газрын 2024 оны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, тухайн онд тавьсан зорилт, хүрэх үр дүнг үнэлэх, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг сайжруулахад зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв бодит мэдээллээр хангах, дараагийн шатны төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

ХОЁР. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Барилга, хот байгуулалтын салбарт хамаарах бодлогын баримт бичиг, холбогдох эрх зүйн акт болон Засгийн газар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын болон Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улс, Нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, байгууллагын ил тод байдал, төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, санал дүгнэлт өгч ажиллаа.

ГУРАВ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ҮР ДҮН

Хяналт шинжилгээ, үнэлгээг Улс, нийслэлээс хэрэгжүүлж буй бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрт Хот байгуулалт, хотын стандартын газрын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт болон бусад мэдээ, тайланд тулгуурлан Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу 3 багц, 14 үзүүлэлтээр дүгнэв.

Төлөвлөсөн арга хэмжээ бүрийн биелэлтийн 2024 онд хүрсэн бодит үр дүнг хүрвэл зохих түвшинтэй харьцуулан хувиар тодорхойлж үнэлгээг гаргахад Газрын ерөнхий үнэлгээ **91,3** хувьтай байна.

Хүснэгт 1. Хот байгуулалт, хотын стандартын газрын
2024 оны үйл ажиллагааны үнэлгээний дүн:

№	Үзүүлэлт		Хувь
1	2	3	4
1	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	85,7
		2. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	95,8
		3. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө	100
		4. Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	83,8
		5. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	87,2
		6. Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө	84,2

1	2	3	4
		7. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр	94,7
Хэсгийн дундаж хувь:			90,2
2	Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө	95,1
		2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр	100
		3. Газрын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүрэг	97,7
		4. Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт	99,3
Хэсгийн дундаж хувь:			98,0
3	Байгууллагын ил тод, нээлттэй байдлын үнэлгээ	1. Газрын мэдээллийн ил тод, нээлттэй байдал	85,1
		2. Төсөв, санхүүгийн ил тод байдал, шилэн дансны хөтлөлт	72,8
		3. Хэрэглэгчийн үнэлгээ	100
Хэсгийн дундаж хувь:			85,9
Ерөнхий үнэлгээ:			91,3

ДӨРӨВ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

4.1. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт.


Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд Газрын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан 8 зорилт, 14 арга хэмжээний 2024 оны хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, **85,7** хувьтай буюу **“Тодорхой үр дүнд хүрсэн”** гэж үнэлэв.

Хэрэгжилтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газарт 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдөр дотоод удирдлагын ERP систем /Х.Нямбаяр/-ээр хүргүүлж, файлыг Газрын дотоод сүлжээнд Z:\0.KHOT BAIGUULALT, KHOTIIN STANDARTIIN GAZAR\4. BIYLELT\5. 2024\1. BODLOGIIN BARIMT BICHIG\2. MU-IIN UNDSSEN CHIGLEL байршуулав.

4.2. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дүгээр тогтоолоор баталсан Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны арга хэмжээний төлөвлөгөөнд Газрын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан 7 зорилт, 14 арга хэмжээний хэрэгжилтийг хангуулж ажилласан байна. Хяналт шинжилгээ, үнэлгээ хийж хэрэгжилтийн түвшин өссөн дүнгээр жилийн эцсийн байдлаар **95,8** хувьтай, **“Тодорхой үр дүнд хүрсэн”** гэж үнэлэв. Үүнд:

Зураг 1. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт:



Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшний тайланг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газарт дотоод удирдлагын ERP системээр хүргүүлж, файлыг Газрын дотоод сүлжээнд Z:\0.KHOT BAIGUULALT, KHOTIIN STANDARTIIN GAZAR\4. BIYELELT\5. 2024\1. BODLOGIIN BARIMT BICHIG\3. ZGUAN байршуулав.

4.3. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт.


Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд Газрын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан 3 арга хэмжээний хэрэгжилтийг хангуулж ажилласан байна. Хяналт шинжилгээ, үнэлгээ хийж хэрэгжилтийн түвшин **100** хувьтай, **“Үр дүнтэй”** гэж үнэлэв.

Төлөвлөгөөний биелэлтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газарт 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдөр дотоод удирдлагын ERP систем /Х.Нямбаяр/-ээр хүргүүлж, файлыг Газрын дотоод сүлжээнд Z:\0.KHOT BAIGUULALT, KHOTIIN STANDARTIIN GAZAR\4. BIYELELT\5. 2024\1. BODLOGIIN BARIMT BICHIG\4. MU-IIN HUGJLIIN 2024 ONI TULUVUGUU байршуулав.

4.4. Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/09 дүгээр тогтоолоор батлагдсан Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд Газрын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан 31 арга хэмжээ, 46 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг хангуулж ажилласан байна. Хяналт шинжилгээ, үнэлгээ хийж арга хэмжээний хэрэгжилтийн дундаж **83,8** хувьтай буюу **“Эрчимжүүлэх шаардлагатай”** гэж үнэлэв.

Зураг 2. Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт:




Төлөвлөгөөний биелэлтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газарт 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр Хяналт шинжилгээ, үнэлгээний <https://control.ulaanbaatar.mn/app> цахим системээр, 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдөр дотоод удирдлагын ERP систем /Х.Нямбаяр/-ээр хүргүүлж, файлыг Газрын дотоод сүлжээнд Z:\0.KHOT BAIGUULALT, KHOTIIN STANDARTIIN GAZAR\4. BIYELELT\5. 2024\4. NIISLELIIN BARIMT BICHIG\1. NIISLELIIG 2021-2025 OND HUGJUULEH UNDSSEN CHIGLEL байршуулав.

4.5. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/10 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024

оны үйл ажиллагааны хөтөлбөрт 2024 оны Газрын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан 17 зорилт, 42 арга хэмжээний нийт 51 зорилтот түвшний хэрэгжилтийг хангуулж ажилласан байна. Хяналт шинжилгээ, үнэлгээ хийж хэрэгжилтийн түвшин **87,2** хувьтай байгаа тул хариуцлагыг нэмэгдүүлж, хөрөнгө шийдвэрлэлтэд анхаарч, хэрэгжилт бага хувьтай үйл ажиллагаа, зорилтод чиглэсэн арга хэмжээг сайжруулах чиглэлээр зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авч ажиллан, **“Тодорхой үр дүнд хүрсэн”** гэж үнэлэв.

Зураг 3. Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт



Хөрөнгө шийдвэрлэгдээгүй арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн саналаа Улс, нийслэлийн 2024, 2025 оны төсвийн төсөлд тусгуулахаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2023 оны 01/01/751, 01/01/1324, 2024 оны 03/1624, 03/3376, 02/201 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлсэн.

Төлөвлөгөөний биелэлтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газарт 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдөр дотоод удирдлагын ERP систем /Х.Нямбаяр/-ээр хүргүүлж, файлыг Газрын дотоод сүлжээнд Z:\0.KHOT BAIGUULALT, KHOTIIN STANDARTIIN GAZAR\4. BIYLELT\5. 2024\4. NIISLELIIN BARIMT BICHIG\2. NIISLELIIN ZASAG DARGIIN 2020-2024 ONII UIL AJILLAGAANII HUTULBUR байршуулав.

4.6. Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 111 дүгээр тогтоолоор батлагдсан Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд Газрын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан 39 арга хэмжээ, 41 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг хангуулж ажилласан байна. Хяналт шинжилгээ, үнэлгээ хийж хэрэгжилтийн түвшин **84,2** хувьтай буюу **“Тодорхой үр дүнд хүрсэн”** гэж үнэлэв.

Төлөвлөгөөний биелэлтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газарт 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр Хяналт шинжилгээ, үнэлгээний <https://control.ulaanbaatar.mn/app> цахим системээр, 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдөр дотоод удирдлагын ERP систем /Х.Нямбаяр/-ээр хүргүүлж, файлыг Газрын дотоод сүлжээнд Z:\0.KHOT BAIGUULALT, KHOTIIN STANDARTIIN GAZAR\4. BIYLELT\5. 2024\4. NIISLELIIN BARIMT BICHIG\3. NIISLELIIN 2024 ONII HUGJLIIN TULUVLUGUU байршуулав.

4.7. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт.


2024 оны жилийн эцсийн байдлаар Газрын үндсэн чиг үүрэгт хамааралтай Монгол Улсын хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, УИХ-ын тогтоол, УИХ-ын Байнгын хорооны тогтоол, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж, Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавар нийлсэн нийт 14 хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 18 заалтыг хяналтад авч, хяналт шинжилгээ, үнэлгээ хийв.

Хүснэгт 2. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн дэлгэрэнгүй дүн:

Үзүүлэлт	Бүгд	Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрүүд								
		Монгол Улсын Хууль	Ерөнхийлөгчийн зарлиг	Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн Зөвлөмж	Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн хуралдааны тэмдэглэл	Улсын Их Хурлын тогтоол	Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол	Засгийн газрын тогтоол	Ерөнхий сайдын захирамж	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо	14	1	-	1	-	3	-	3	-	6
Хяналтад авсан нийт заалтын тоо	18	1	-	1	-	4	-	5	-	7
Үүнээс	Бүрэн хэрэгжсэн 100%	14	-	-	1	-	2	-	4	-
	Хэрэгжих шатанд 70%	3	1	-	-	-	2	-	-	-
	Хэрэгжилт хангалтгүй 30%	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэрэгжээгүй 0%	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	-	-	-	-	-	-	-	-	-
	Тус газрын чиг үүрэгт хамааралгүй	1	-	-	-	-	-	1	-	-
Биелэлтийн дүн (хувь)		94.7%	70%	-	100%	-	85%	-	100%	-

Хяналтад авсан 18 заалтын Бүрэн хэрэгжсэн буюу 100 хувийн хэрэгжилттэй 14, хэрэгжих шатанд байгаа буюу 70 хувийн хэрэгжилттэй 3, хасуулах саналтай 1 заалт байгаа бөгөөд хэрэгжилтийн дундаж **94,7** хувь буюу **“Бүрэн хэрэгжсэн”** гэж үнэлэгдэв.

Зураг 4. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ:



Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газарт 2024 оны 01/01/146, 01-01/468, дугаартай албан бичгээр хүргүүлж, файлыг Газрын дотоод сүлжээнд Z:\0.KHOT BAIGUULALT, KHOTIIN STANDARTIIN GAZAR\4. BIYLELT\5. 2024\2. HUULI TOGTOOM, TOGTOOL SHIIDBER байршуулав.

ТАВ. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

3.1. Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт.

Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлэн ажиллав. Үүнд:

- Хоёрдугаар улирлын хэрэгжилтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газарт 2024 оны 01/37 дугаартай албан бичгээр,
- Дөрөвдүгээр улирлын хэрэгжилтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газарт 2024 оны 02/224 дугаар албан бичгээр тус тус хүргүүлж, файлыг Газрын дотоод сүлжээнд Z:\0.KHOT BAIGUULALT, KHOTIIN STANDARTIIN GAZAR\2. GUITSETGELIIN TULUVLUGUU BOLON BUSAD TULUVLUGUU\5. 2024 байршуулав.

3.2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ нийх нийтлэг журам”-ын 4 дүгээр хавсралтаар хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллуулах, хөгжүүлэх, идэвхжүүлэх, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах талаар байгууллагын зүгээс хэрэгжүүлэх үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг баталсан.

Үүний дагуу хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах 2 зорилт, 7 үйл ажиллагааны биелэлтийг 25 шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлсэн.

Хүснэгт 4. Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааг хангах үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт:

№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлтийн тоо	Хэрэгжилт (Хувиар)
1	2	3	4
1. Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх			
1	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	11	100
2	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	6	100
3	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	2	100
2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах			
4	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	2	100
5	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	1	100
6	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	2	100
7	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	1	100
Нийт		25	100

Хөтөлбөрийн биелэлтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн удирдлагын тасагт 2024 оны 01-01/247 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

3.3. Газрын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийн хэрэгжилт.

Нийслэлийн Засаг даргын 2024 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай” А/478 дугаар захирамжаар батлагдсан Газрын дүрмийн 4.1-д үндсэн 18 чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгагдсан бөгөөд 2024 оны байдлаар **97,7** хувьтай буюу **“Тодорхой үр дүнд хүрсэн”** гэж үнэлэв.

Үүнээс “үр дүнтэй” буюу 100 хувийн хэрэгжилттэй 16 чиг үүрэг, “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 90 хувийн хэрэгжилттэй 1 чиг үүрэг, “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 70 хувийн хэрэгжилттэй 1 чиг үүрэг үнэлэгдсэн.

3.4. Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт.

Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/111 дүгээр захирамжаар батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн “eDoc” систем ашиглах журам” болон Газрын даргын 2021 оны А/22 дугаар тушаалаар батлагдсан газрын “Албан хэрэг хөтлөлтийн журам”-ыг мөрдлөг болгон ажиллаж байна.

2024 оны байдлаар байгууллагын хэмжээнд нийт 3854 бичиг ирсэн. Үүнээс:

- Хугацаанд нь хариу өгч шийдвэрлэсэн - 3758
- Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн - 18
- Шийдвэрлэх хугацаандаа судлагдаж байгаа - 78

Албан бичгийн шийдвэрлэлтийн хувь 99,7 хувь, шийдвэрлэлтийн дундаж хугацаа **7 хоног** байна.



2024 оны байдлаар иргэдээс нийт 2126 өргөдөл, гомдол гаргасан байна. Үүнээс:

- Хугацаандаа шийдвэрлэсэн 2103,
- Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 4,
- Хугацаандаа судлагдаж байгаа 19,
- Шийдвэрлэлтийн дундаж хугацаа **10 хоног**, 13 цаг, 13 минут байна.

2023 оны мөн үетэй харьцуулбал:

- | | |
|---------------------------------|--|
| - Өргөдөл, гомдлын хандалт | 356 буюу 14,3 хувиар буурсан, |
| - Шийдвэрлэлтийн дундаж | 1,0%-аар өссөн, |
| - Өргөдөл, гомдлын индекс | 0.2 өссөн, |
| - Шийдвэрлэлтийн дундаж хугацаа | 1 хоног, 4 цагаар өссөн үзүүлэлттэй байна. |

Зураг 6. Өргөдөл, гомдлын хандалтын эх үүсвэр: Зураг 7. Өргөдөл, гомдлын төрөл:



Зураг 8. Шийдвэрлэсэн 2107 өргөдөл, гомдолд хариу өгч, шийдвэрлэсэн хэлбэр:



Хүснэгт 5. Алба, хэлтсийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт.

Д/д	Алба, хэлтэс	Нийт	Шийдвэрлэсэн		Судлах шатанд	Зөрчил	Шийдвэрлэлтийн дундаж хугацаа
			Хугацаанд нь шийдвэрлэсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн			
1	2	3	4	5	6	7	8
1	Удирдлага	-	-	-	-	1	-
2	Захиргаа, удирдлагын хэлтэс	63	63	-	-	1	5 хоног, 18 цаг
3	Ерөнхий архитекторын ажлын алба	51	49	-	2	3	9 хоног, 7 цаг
4	Барилга, хот байгуулалтын хэлтэс	311	305	2	4	12	9 хоног, 18 цаг
5	Хот төлөвлөлтийн хэлтэс	381	377	-	4	8	7 хоног, 12 цаг
6	Хот байгуулалтын инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтэс	53	49	1	3	3	9 хоног, 22 цаг
7	Хотын орон зайн мэдээлэл, технологийн хэлтэс	24	24	-	-	-	5 хоног, 3 цаг
8	Барилга байгууламжийн чанар, стандартын хэлтэс	31	31	-	-	1	7 хоног, 16 цаг
9	Дэд төв, дагуул хотын хөгжлийн хэлтэс	10	10	-	-	1	7 хоног, 16 цаг
10	Хотын стандарт, хөгжлийн хэлтэс	17	17	-	-	3	9 хоног, 4 цаг
11	Хуулийн хэлтэс	111	110	1	-	2	10 хоног, 0 цаг
12	Хот байгуулалтын хяналтын хэлтэс	914	908	-	6	13	13 хоног, 12 цаг
13	Хэсэгчилсэн төлөвлөлтийн хэлтэс	160	160	-	-	1	6 хоног, 22 цаг
Хот байгуулалт, хотын стандартын газар		2126	2103	4	19	49	10 хоног, 13 цаг, 23 минут

Иргэдээс ирүүлсэн 3 талархал:

✓ M240416004 - Хэсэгчилсэн төлөвлөлтийн хэлтэст,

- ✓ С240111009 - Хотын орон зайн мэдээлэл, технологийн хэлтэст,
- ✓ G241014023 - Барилга, хот байгуулалтын хэлтэст ирүүлсэн байна.

Тус газарт иргэдээс гаргасан нийт 2126 өргөдөл, гомдлыг шийдвэрлэх явцад үүссэн 49 зөрчилд хяналт шинжилгээ хийхэд:

- | | |
|-----------------------------------|---|
| ✓ Өдөрт нь багтаан хүлээн аваагүй | 28 буюу 57,1 хувь, |
| ✓ Явцын тэмдэглэл хөтлөөгүй | 14 буюу 28,6 хувь, |
| ✓ Өдөрт нь багтаан шилжүүлээгүй | 4 буюу 8,2 хувь, |
| ✓ Хангалтгүй шийдвэрлэсэн | 3 буюу 6,1 хувийн зөрчил тус тус бүртгэгдсэн байна. |

Зөрчлийн үзүүлэлтийг 2023 оны мөн үетэй харьцуулбал 2023 онд 120 зөрчил бүртгэгдсэн бол 2024 онд 49 болж, 71 буюу 59,1 хувиар буурсан байна.

Зураг 9. Өргөдөл, гомдлын тэргүүлэх 5 хандалт.




Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдалд улирал бүр хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын газрын нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвд хүргүүлэн ажиллав. Үүнд:

- Нэгдүгээр улиралд 01-01/799 тоот албан бичиг,
- Хоёрдугаар улиралд 01/484 тоот албан бичиг,
- Гуравдугаар улиралд 01/0205 тоот албан бичиг,
- Дөрөвдүгээр улиралд 01/035 тоот албан бичиг.

Хүн ам, барилгажилтын нягтрал ихсэж байгаатай холбоотой иргэдийн хараа хяналт нэмэгдэж, барилга, байгууламжийн ажил зөвшөөрөлтэй эсэхийг шалгуулах, барилгын ажил зогсоох, орчин тойрны аюулгүй байдалдаа санаа тавих, хот байгуулалт, төлөвлөлттэй холбоотой мэдээ, мэдээлэл авах зорилготой Засгийн газрын 11-11 төв, Яармаг дахь нэг цэгийн үйлчилгээгээр болон нийслэлийн Лавлагаа мэдээллийн 1800-1200 тусгай дугаарын утсаар хандаж, өргөдөл, гомдол гаргах иргэдийн хандалтын тоо жил тутам өссөн бөгөөд 2024 онд өмнөх оноос 356 буюу 14,3 хувиар бууруулсан байна.

Зураг 10. Өргөдөл, гомдлын хандалтыг өмнөх онуудтай харьцуулбал:



ЗУРГАА. БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

6.1. Газрын мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилт.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу байгууллагын цахим хуудсанд дахь мэдээллийг 2024 онд тогтмол хариуцан шинэчлэн ажиллах алба, хэлтсүүдийг Газрын даргаар 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр батлуулж, Газрын цахим хуудас дахь мэдээ, мэдээллийг тогтмол тухай бүр шинэчлэх, ойлгомжтой байдлаар байршуулах зарчмаар мэдээллийн сангийн тасралтгүй үйл ажиллагааг хөтлөн явуулж байна.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийг хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9 дүгээр хавсралтаар батлагдсан

“Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийг тайлагнах хүснэгт”-ийн дагуу Газрын хамаарал бүхий 38 төрлийн мэдээллийн ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт 2024 оны байдлаар **85,1** хувь буюу **"Тодорхой үр дүнд хүрсэн"** хэрэгжилттэй байна.

Зураг 11. Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт:



Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах үүднээс байгууллагын үйл ажиллагааны тайлан, мэдээ, барилгын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл, хууль, эрх зүй болон дотоод дүрэм, журам, албан бичгийн шийдвэрлэлт, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт зэрэг мэдээллийг Газрын <http://uda.ub.gov.mn/> цахим хуудсанд байршуулан ажиллаж байна.

Мэргэжлийн зөвлөлийн хурлыг иргэд, олон нийтэд нээлттэй болгож, байгууллагын цахим хуудас болон YouTube хуудсаар шууд дамжуулан хүргэж, хурлын жагсаалт, санал, дүгнэлтийг байршуулсан.

Газрын үйлчилгээг видео хэлбэрээр олон нийтэд ойлгомжтой хүргэж, мэдээллийн хүртээмжтэй байдлыг хангах үүднээс YouTube хуудасны албан ёсны (https://www.youtube.com/@user-vf4lz5sc2w/videos?view=0&sort=dd&shelf_id=0) сувагт 66 дүрст мэдээ, мэдээллийг байршуулсан байна.

Газрын <http://uda.ub.gov.mn> цахим хуудас нь нийт 41 цэсээс бүрдэх бөгөөд 2024 оны байдлаар 23 дэд цэсийн холбогдох хэсэгт 331 төрлийн мэдээ, мэдээллийг шинэчлэн байршуулсан байна.

“Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох үнэлгээ хийх журам”-ын 4.1-д заасны дагуу нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст 2024 оны 01-01/267 дугаартай албан бичгээр хүргүүлэв.

6.2. Төсөв, санхүүгийн ил тод байдал, шилэн дансны хөтлөлт.

Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах үүднээс Газрын <http://uda.ub.gov.mn> цахим хуудас болон <https://shilendans.gov.mn/> цахим хуудсанд төсвийн гүйцэтгэл, хөрөнгө оруулалт болон бусад төсөв, санхүүгийн мэдээллийг тогтмол баяжуулан ажилласан байна.

- Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл;
- Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;
- “Шилэн данс” цэсийг газрын цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулах,
- “Тендер, төсөл” цэсэд 2023 оны байдлаар тендер, төсөл хөтөлбөрийн мэдээ, мэдээллийг шинэчлэн байршуулах
- Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт;
- Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл;
- Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн;
- Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайланг байршуулах.

Зураг 12. Хот байгуулалт, хөгжлийн газрын “Шилэн данс” хөтлөлт.

<https://shilendans.gov.mn/organization/56564>

НД	Тайлбар	Мэдээлэл оруулах хугацаа	Базал	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл - Хотонбор, оронсуулт	дөрөв сарын 8-ны дотор	*	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
2	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэргэлт дэмжлэгийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал	дөрөв сарын 8-ны дотор	*	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
3	Санхүүгийн тайлан	хагас жилийн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор	*					✓							
4	Хөндөв, тусламжийн орлого	хагас жилийн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор	*					✓							

Тендер, худалдан авалт болон бусад мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <https://www.tender.gov.mn/>, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем <https://pimis.publicinvestment.gov.mn/>-д байршуулан ажиллаж байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт, мэргэжил арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээ, мэдээллийг Газрын цахим хуудасны “Тендер” цэсэд шинээр нэмж байршуулах шаардлагатай байна.

Байгууллагын төсөв, санхүүгийн ил тод байдал, шилэн дансны хуулийн хэрэгжилт, тайлан, мэдээг хуулийн хугацаанд үнэн, зөв, иж бүрэн байршуулж байгаад болон хууль, журмын хэрэгжилтийг сайжруулах зорилгоор Засгийн газрын 2020 оны 206 дугаар

тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийг хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 9 дүгээр хавсралтын дагуу 2024 оны жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд 72,8 хувийн үзүүлэлттэй байна.

ДОЛОО. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Улс, нийслэлээс хэрэгжүүлж буй бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрт Хот байгуулалт, хөгжлийн газрын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт болон бусад мэдээ, тайланд тулгуурлан Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу 3 багц, 14 үзүүлэлтээр хяналт шинжилгээ, үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэв.

Төлөвлөсөн арга хэмжээ бүрийн биелэлтийн 2024 онд хүрсэн бодит үр дүнг хүрвэл зохих түвшинтэй харьцуулан хувиар тодорхойлж үнэлгээг гаргахад Газрын ерөнхий үнэлгээ **91,3** хувь буюу **"Тодорхой үр дүнд хүрсэн"** байна.

7.1. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ.

Бодлогын баримт бичгийн 7 шалгуур үзүүлэлтийн хэсгийн дундаж **90,2** хувь буюу **"Үр дүнтэй"** үзүүлэлттэй үнэлэгдсэн.

- Тодорхой шалтгааны улмаас хэрэгжилт удаашралтай заалтуудын шалтгаан нөхцөлийг тодорхойлж, цаашид авах арга хэмжээний талаарх саналыг хэлэлцэн шийдвэрлэж байх,
- Бодлогын баримт бичигт тусгагдсан Газарт хамаарал бүхий ажлыг ямар нэгэн чиглэл хүлээлгүй санаачилгатай хийж, хэрэгжүүлэн тайлагнах нь зүйтэй. Мөн алба, хэлтсийн дарга нар хүргүүлж буй тайлантай бүрэн танилцсан байхыг хэвшил болгох,
- Төлөвлөгөөний хүрсэн түвшин, хэрэгжилтийг товч тодорхой, шалгуур үзүүлэлтийн дагуу, тоо, хувь, нотлох баримттай тайлагнаж хэвших,
- Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн заалт тус бүрт хяналтын карт хөтлөн холбогдох алба, хэлтсийн даргад хүлээлгэн өгч, хяналтад бүрэн авч, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр нэгтгэн тайлагнах шаардлагатай байна.

7.2. Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ.

Байгууллагын чиг үүргийн 4 шалгуур үзүүлэлтийн хэсгийн дундаж **98,0** хувь буюу **"Үр дүнтэй"** үзүүлэлттэй үнэлэгдсэн.

- Алба, хэлтсүүд жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа "Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө болон Нийслэлийн 2020-2024 оны Стратеги төлөвлөгөөтэй нягт уялдуулж төлөвлөх, шалгуур үзүүлэлтийг тодорхойлохдоо анхаарах;
- Тайланг бодитой, товч тодорхой, нэг ажил, арга хэмжээний гүйцэтгэлийг 2000 тэмдэгтэд багтаах, тухайн ажлын гүйцэтгэл нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх, хүрээгүй бол түүний шалтгаан, нөхцөлийг заавал тодорхой дурдах гэсэн тусгай шаардлагуудыг заавал хангаж байх,
- Алба, хэлтсүүд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт хөрөнгө шийдвэрлэгдээгүйн улмаас удаашралтай, хэрэгжих нөхцөл бүрдээгүй 5 арга хэмжээг Улс, нийслэлийн 2024 оны төсвийн төсөлд тусгуулах ажлыг зохион байгуулах,
- Газрын дүрмээр хүлээх үндсэн чиг үүргийн 70 хувийн хэрэгжилттэй ажлыг тодорхой үр дүнд хүргэхэд анхаарч, 2025 онд бүрэн хэрэгжүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

Албан бичиг, өргөдөл, гомдлын чиглэлээр:

- Иргэдээс нэг ижил утгатай, нэг иргэнээс дахин хандсан өргөдөл, гомдлыг холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд өргөдөл, гомдолд дурдсан асуудлыг бүх талаас нь нягтлан судалж, хууль зүйн үндэслэлтэй, нэг мөр, эцэслэн шийдвэрлэхэд анхаарах.
- Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам болон Газраас баримтлах бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагаандаа иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтэд агуулагдсан санал, санаачилгыг тусгахад анхаарах,
- Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэхэд иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн үзүүлэлтийг харгалзан үзэх.
- Өргөдөл, гомдлын хариуг иргэнд цахимаар, утсаар, шуудангаар, биечлэн аль ч хэлбэрээр өгсөн байхаас үл хамаарч өргөдөл, гомдлын дэд системд шийдвэрлэлтийг дэлгэрэнгүй тэмдэглэж, холбогдох файлыг хавсаргана. ("Иргэдээс Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам"-ын 8.2 дахь хэсэг)
- Өргөдөл, гомдлыг өдөрт нь багтаан хүлээн аваагүй зөрчил дийлэнх хувийг эзэлж байгаатай холбогдуулан нэгжийн дарга, ахлах мэргэжилтэн болон нийт албан хаагчид анхаарч ажиллах,
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхдээ системд явцын тэмдэглэл хөтлөх, хаалтын үйлдлийг гүйцэтгэхдээ иргэний овог, нэр, утасны дугаарыг тэмдэглэхгүй байхад анхаарч ажиллах шаардлагатай байна.

7.3. Байгууллагын ил тод, нээлттэй байдлын үнэлгээ.

Байгууллагын ил тод, нээлттэй байдлын 3 шалгуур үзүүлэлтийн хэсгийн дундаж **85,9** хувь буюу **"Тодорхой үр дүнд хүрсэн"** гэж үнэлэгдсэн.

- Газрын <http://uda.ub.gov.mn> цахим хуудсанд хөгжүүлэлт хийх шаардлагатай байна. Тухайлбал: "Үндсэн веб" хуудсанд байршуулсан мэдээ, мэдээллийн загвар, дизайныг шинэчилж, хэрэглэгч, үйлчлүүлэгчдэд хэрэглэхэд ойлгомжтой, хялбар бүтэцтэй болгох, (Бусад байгууллагын цахим хуудастай харьцуулж, хөгжүүлэлтийг хийх.)
- Цахим хуудсанд байршуулсан мэдээллийн дийлэнх хувь нь Газрын лого байна. Иймд тухайн мэдээ, мэдээлэлд тохирох icon, зураг оруулах,
- Газрын цахим хуудасны мэдээ, мэдээллийг Facebook page, YouTube channel, Twitter гэх мэт мэдээллийн олон сурвалж ашиглан, холбоос линк үүсгэн сошиалд хүргэх хүртээмжийг нэмэгдүүлэх талаар санаачилгатай ажиллах,
- Нийгмийн олон нийтийн сүлжээний "Хот байгуулалт, хөгжлийн газар" нэртэй албан ёсны Facebook page хуудсанд байршуулсан шинэ мэдээ, мэдээллийг Газрын <http://uda.ub.gov.mn> цахим хуудсанд тогтмол байршуулж хэвших,
- Алба, хэлтсүүд өөрийн хариуцах асуудлын хүрээнд цахим хуудсанд байршуулсан мэдээ, мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд тухай бүр шинэчлэгдсэн мэдээллийг бүрэн байршуулж, тогтмол шинэчилж байх талаар анхаарах,
- Газрын цахим хуудсаар дамжуулан байгууллагаас үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар иргэд, олон нийтээс сэтгэл ханамжийн судалгааг авч, жил бүрийн үр дүнг харьцуулан дүгнэлт хийж, мэдээллийг ил тод, нээлттэй байршуулж ажиллах шаардлагатай байна.

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Т.БУЯНЖАРГАЛ

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ӨРГӨДӨЛ ГОМДОЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



Л.АДЪЯАСҮРЭН

БАТЛАВ
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ
Г.БАТЗОРИГ

2024 оны 03 дугаар сарын 26-ны өдөр

ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНД ХИЙХ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ 2024 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Улаанбаатар хот

2024 оны 03 дугаар сарын 25

Д/д	Төлөвлөсөн арга хэмжээ	Хүрэх үр дүн	Хугацаа	Хариуцах эзэн	Хамрах хүрээ
1	2	3	4	5	6
1	Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрээс Хот байгуулалтын чиг үүрэг бүхий хяналтад авсан зүйл заалтын хэрэгжилтийн байдалд явцын болон эцсийн хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, Захиргааны зөвлөлийн хуралд танилцуулах, алба, хэлтсүүдэд зөвлөмж өгч, хяналт тавьж ажиллах;	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын дагуу газрын чиг үүргийн хамаарал бүхий бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангагдана.	2024.06.30 2024.12.31	Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн	Алба, хэлтсүүд
2	Гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, Захиргааны зөвлөлийн хуралд танилцуулах, алба, хэлтсүүдэд зөвлөмж өгч, хяналт тавьж ажиллах;	Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт хангагдан гүйцэтгэл сайжирна.	2024.07.15 2024.12.31	Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн	Алба, хэлтсүүд
3	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт, газрын цахим хуудасны ил тод байдалд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, Захиргааны зөвлөлийн хуралд танилцуулах, алба, хэлтсүүдэд зөвлөмж өгч, хяналт тавьж ажиллах;	Иргэн, хуулийн этгээдэд газрын үйл ажиллагаа нээлттэй болж, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт хангагдана.	2024.07.25 2024.12.31	Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн	Хот байгуулалтын мэдээллийн хэлтэс

1	2	3	4	5	6
4	Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдалд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, Захиргааны зөвлөлийн хуралд танилцуулах, зөвлөмж өгч, хяналт тавьж ажиллах;	Албан хаагчдын ажил үүргийн болон нийгмийн баталгаа хангагдан тогтвортой төрийн алба хаах нөхцөл бүрдсэн байна.	2024.07.25 2024.12.31	Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн	Захиргаа, санхүүгийн хэлтэс
5	Төсөв, санхүүгийн ил тод байдал, шилэн дансны хөтлөлтөд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, Захиргааны зөвлөлийн хуралд танилцуулах, зөвлөмж өгч, хяналт тавьж ажиллах;	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангагдаж, https://shilendans.gov.mn/ цахим системд цаг хугацаанд нь мэдээллийг байршуулсан байна.	2024.07.25 2024.12.31	Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн	Захиргаа, санхүүгийн хэлтэс
6	Газраас үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдалд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, Захиргааны зөвлөлийн хуралд танилцуулах, алба, хэлтсүүдэд зөвлөмж өгч, хяналт тавьж ажиллах;	Газрын үйлчилгээ түргэн шуурхай, ил тод нээлттэй болж, хугацаа богиносно.	2024.07.25 2024.12.31	Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн	Алба, хэлтсүүд
7	Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдалд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, Захиргааны зөвлөлийн хуралд танилцуулах, алба, хэлтсүүдэд зөвлөмж өгч, хяналт тавьж ажиллах;	Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацааг нэг оронтой тоонд барина.	2024.03.31 2024.06.30 2024.09.30 2024.12.31	Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн, Дотоод ажил, өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн, Бичиг хэргийн ажилтан	Алба, хэлтсүүд
8	Дээд газраас ирүүлсэн хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах;	Санал, зөвлөмжийн хэрэгжилт хангагдсан байна.	2024.06.30 2024.12.31	Биелэлт хариуцсан ахлах мэргэжилтэн, Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн	Алба, хэлтсүүд

ХЯНАСАН: ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Ч.БАДАМХАНД

БОЛОВСРУУЛСАН:

ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНД ХИЙХ
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Л.АДЪЯАСҮРЭН

ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНД ХИЙХ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ 2024 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2024 оны 11 дүгээр сарын 29

Улаанбаатар хот

Д/д	Төлөвлөсөн арга хэмжээ	Хүрэх үр дүн	Хэрэгжилт	Хувь
1	2	3	4	5
1	Бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэрээс Хот байгуулалтын чиг үүрэг бүхий хяналтад авсан зүйл заалтын хэрэгжилтийн байдалд явцын болон эцсийн хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, Захиргааны зөвлөлийн хуралд танилцуулах, алба, хэлтсүүдэд зөвлөмж өгч, хяналт тавьж ажиллах;	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын дагуу газрын чиг үүргийн хамаарал бүхий бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангагдана.	Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд тухай бүр хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, холбогдох алба, хэлтсүүдэд санал, зөвлөмж өгч, Захиргааны зөвлөлийн хурлаар танилцуулж ажиллав. Мөн биелэлт, тайланг дээд шатны байгууллагад хүргүүлэв. Үүнд: БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ: 1. “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” дунд хугацааны төлөвлөлтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн 2024 оны эхний хагас жилийн тайланг 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр нэгтгэн боловсруулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүлгүүлэв. 2. “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны 01 дүгээр сарын биелэлтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Дотоод удирдлагын erp.ulaanbaatar.mn системээр Р.Энх-Ирээдүй)-т 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр хүргүүлэв. 3. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлэв. (7 зорилтын 12 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 95,0 хувьтай байна.) 4. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2023 оны төлөвлөгөөний	100

1	2	3	4	5
			хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэтэст 2024 оны 01/01/147 дугаартай албан бичгээр хүргүүлэв. (Нийт 14 зорилт, 39 арга хэмжээний 45 зорилтот түвшин тусгагдаж, хэрэгжилт 76.0 хувиар үнэлэгдэв.) 5. Нийслэлийн 2021-2024 оны Стратеги төлөвлөгөөний хэрэгжилт (2021-2023 оны байдлаар буюу өссөн дүнгээр)-ийн тайланг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Дотоод удирдлагын erp.ulaanbaatar.mn системээр Р.Энх-Ирээдүй)-т 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдөр хүргүүлэв. 6. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хагас жилийн биелэлтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газарт 2024 оны 01-01/466 дугаар албан бичгээр хүргүүлэв. 7. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газарт 2024 оны 01-01/463 дугаар албан бичгээр хүргүүлэв. 8. Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гуравдугаар улирлын хэрэгжилтийг (Дотоод удирдлагын erp.ulaanbaatar.mn системийн Хяналт шинжилгээ, үнэлгээний системээр болон мэргэжилтэн Р.Энх-Ирээдүй)-т 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдөр хүргүүлэв. ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ, ШИЙДВЭР: 9. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын 2023 оны 138 дугаар зөвлөмжийн жилийн эцсийн хэрэгжилтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст 2024 оны 01/01/22 дугаартай албан бичгээр хүргүүлэв. 10. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 2023 оны хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст 2024 оны	

1	2	3	4	5
			01/01/146 дугаартай албан бичгээр болон дотоод удирдлагын erp.ulaanbaatar.mn цахим системээр хүргүүлэв. 11. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд 2024 оны 01-05 дугаар сарын байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст (дотоод удирдлагын ERP системээр О.Тунгалаг) хүргүүлэв. 12. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2003 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотод баригдах орон сууц, үйлчилгээний барилга, байгууламжийн зураг төслийг зөвшөөрөлцөх, захиалагчийн техникийн хяналт хийхэд мөрдөх журам”, 2010 оны 55 дугаар тогтоолоор батлагдсан “Улсын нийслэлд хөшөө, дурсгал хүндэтгэлийн самбар байрлуулах журам”, 2010 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээг мэдээллийн санд бүртгэх журам”, Хурлын 2019 оны 24/17 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт хашаа, хайс барих, ашиглах, буулгах журам”-ын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, танилцуулгыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2024 оны 01-01/703 дугаартай албан бичгээр хүргүүлэв. 13. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 2024 оны хагас жилийн хэрэгжилт, хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын танилцуулгын хамт Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газарт 2024 оны 01-01/468 дугаар албан бичгээр хүргүүлэв. 14. Нийслэлийн Засаг даргын 2024 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” захирамжийн хэрэгжилтийн явцын дэлгэрэнгүй танилцуулгыг 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нэгтгэн гаргаж Газрын даргад танилцуулан, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газрын Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилт, үр дүнд хийх хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэнд дотоод удирдлагын ERP чатаар хүргүүлэв.	

1	2	3	4	5
2	Гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, Захиргааны зөвлөлийн хуралд танилцуулах, алба, хэлтсүүдэд зөвлөмж өгч, хяналт тавьж ажиллах;	Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт хангагдан гүйцэтгэл сайжирна.	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 04 дүгээр хавсралтаар баталсан загвараар Газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 бүлэг, 27 зорилт, 149 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр нэгтгэн боловсруулж, Нийслэлийн Засаг даргаар батлуулав. Газрын 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хагас, бүтэн жилээр хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, алба, хэлтсүүдэд санал, зөвлөмж өгч, Захиргааны зөвлөлийн хурлаар танилцуулан ажиллав. Мөн биелэлт, тайланг дээд шатны байгууллагад хүргүүлэв. Үүнд: - Газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас жилийн биелэлт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн ажлын танилцуулгын хамт Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн Бодлого, төлөвлөлтийн газрын Дэд бүтэц, хөгжлийн бодлогын хэлтэст 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 01-01/418 дугаартай албан бичгээр хүргүүлэн ажиллав.	100
3	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт, газрын цахим хуудасны ил тод байдалд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, Захиргааны зөвлөлийн хуралд танилцуулах, алба, хэлтсүүдэд зөвлөмж өгч, хяналт тавьж ажиллах;	Иргэн, хуулийн этгээдэд газрын үйл ажиллагаа нээлттэй болж, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт хангагдана.	- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу байгууллагын цахим хуудсан дах мэдээллийг 2024 онд тогтмол хариуцан шинэчлэн ажиллах алба, хэлтсүүдийг 2024 оны 03 дүгээр сарын 25-ны өдөр Газрын даргаар батлуулан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллав. - Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу байгууллагын цахим хуудас дахь мэдээлэлд 2024 оны хагас, бүтэн жилийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, алба, хэлтсүүдэд санал, зөвлөмж хүргүүлэв. Z:\0.KHOT BAIGUULALT, KHUGJLIIN GAZAR\4. BIYLELT\5. 2024\5. MONITORING\3. МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ	100
4	Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдалд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, Захиргааны зөвлөлийн хуралд танилцуулах, зөвлөмж өгч, хяналт тавьж ажиллах;	Албан хаагчдын ажил үүргийн болон нийгмийн баталгаа хангагдан тогтвортой төрийн алба хаах нөхцөл бүрдсэн байна.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдалд 2024 оны хагас, бүтэн жилийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээний ажлыг хийж, санал, зөвлөмж хүргүүлэв. (Хагас жилийн хэрэгжилт 95.0 хувь, жилийн эцсийн байдлаар 100 хувь)	100

1	2	3	4	5
5	Төсөв, санхүүгийн ил тод байдал, шилэн дансны хөтлөлтөд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, Захиргааны зөвлөлийн хуралд танилцуулах, зөвлөмж өгч, хяналт тавьж ажиллах;	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангагдаж, шилэн дансны мэдээллийг https://shilendans.gov.mn/ цахим системд цаг хугацаанд байршуулсан байна.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу Төсөв, санхүүгийн ил тод байдал, шилэн дансны хөтлөлтөд 2023 оны хагас, бүтэн жилийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээний ажлыг хийж, санал, зөвлөмж хүргүүлэв. (Хагас жилийн хэрэгжилт 67.1 хувь, жилийн эцсийн байдлаар 72.8 хувь)	100
6	Газраас үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдалд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, Захиргааны зөвлөлийн хуралд танилцуулах, алба, хэлтсүүдэд зөвлөмж өгч, хяналт тавьж ажиллах;	Газрын үйлчилгээ түргэн шуурхай, ил тод, нээлттэй болж, хугацаа богиносно.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу Газраас үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдалд 2024 оны хагас, бүтэн жилийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээний ажлыг хийж, санал, зөвлөмж хүргүүлэв. (Хагас жилийн хэрэгжилт 95.0 хувь, жилийн эцсийн байдлаар 100 хувь)	100
7	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдалд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, Захиргааны зөвлөлийн хуралд танилцуулах, алба, хэлтсүүдэд зөвлөмж өгч, хяналт тавьж ажиллах;	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацааг нэг оронтой тоонд барина.	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдалд улирал бүр хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, алба, хэлтсүүдэд санал, зөвлөмж хүргүүлэн, Захиргааны зөвлөлийн хурлаар танилцуулж ажиллав. Мөн өдөр тутмын шийдвэрлэлтийн байдалд хяналт тавьж, тайлан мэдээг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын газрын нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвд хүргүүлэн ажиллав. Үүнд: - Нэгдүгээр улиралд 01-01/799 тоот албан бичиг, - Хоёрдугаар улиралд 01/484 тоот албан бичиг, - Гуравдугаар улиралд 01/0205 тоот албан бичиг.	100
8	Дээд газраас ирүүлсэн хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах;	Газрын үйл ажиллагааны үр дүн нэмэгдсэн байна.	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны 03/6352 дугаар албан бичгээр "Иргэдээс 2021-2023 онд гаргасан гомдлын шийдвэрлэлтэд хөндлөнгийн үнэлгээг хараат бус судалгааны байгууллагаар хийж гүйцэтгэсэн"-ий дагуу чиглэл хүргүүлсэн. Уг чиглэлийн дагуу гомдол (шууд шийдвэрлэх боломжгүй)-уудыг сууриар нь арилгахад хууль, эрх зүйн өөрчлөлт, шинэчлэлт, төсөв, санхүү болон хүний нөөцийн дутагдалтай байдлыг арилгах талаарх саналаа 2024 оны 11 дүгээр сарын 20-ны	100


1	2	3	4	5
			өдрийн 01/478 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын газрын нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвд хүргүүлэн ажиллав.	

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

ТАЙЛАН ГАРГАСАН:

ӨРГӨДӨЛ ГОМДОЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



Д.ДАШЦЭЦЭГ

Л.АДЪЯАСҮРЭН